



ДУНДГОВЬ АЙМАГ  
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 1/29

Мандалговь

Төрийн үйлчилгээний албан хаагчдад  
ур чадварын нэмэгдэл, төрийн жинхэнэ албан хаагч нарт  
ажлын гүйцэтгэлийн урамшуулалт олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 6 сарын 4-ний өдрийн 47 дугаартай тушаал, Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Мал эмнэлгийн газрын даргын 2018 оны 12 сарын 31-ний өдрийн A/03 дугаартай тушаал зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мал эмнэлгийн газрын ур чадварын нэмэгдлийг сар бүрээр тооцож олгох албан хаагчийн нэрсийг тушаалын 1-р хавсралтаар баталсугай.
2. Мал эмнэлгийн газрын албан хаагчдад ажлын гүйцэтгэлийн үндэслэн урамшуулалт олгох төрийн жинхэнэ албан хаагчийн нэрсийн жагсаалтыг тушаалын 2-р хавсралтаар баталсугай.
3. Нийт албан хаагчдад ур чадварын нэмэгдэл, албан хаагчдад ажлын гүйцэтгэлийн урамшуулалд зарцуулвал зохих хөрөнгийг үндсэн цалингийн зардлаас зарцуулж, энэхүү тушаалын хавсралтанд заасны дагуу олгохыг нягтлан бодогч /Ж.Болор-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн албаны дарга /Г.Нямаа/-д даалгасугай.

ДАРГА



Ш.МӨНХДҮҮРЭН

4801000133